



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2021.10.10 № 2627

танай _____-ны № _____-т

Аудитын сэдвийн төсөл хүргүүлэх тухай


Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ" гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг батлуулахаар 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 1688 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Төсвийн байнгын хорооноос зарим чиглэл ирүүлсний дагуу аудитын сэдвийн төсөлд холбогдох өөрчлөлтийг хийж, Төрийн аудитын байгууллагаас 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хүргүүлж байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг Байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Тогтоолын төсөл, аудитын сэдэв холбогдох судалгааг хавсаргав.

Хавсралт ... хуудастай.



Д.ЗАНДАНБАТ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

Аудитын сэдэв батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Төрийн аудитын байгууллагаас 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг ханган, аудитыг цаг хугацаанд нь чанарын өндөр төвшинд хийж гүйцэтгэж, аудитын тайланг Улсын Их Хурлын Байнгын хороодод хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Занданбат/-т үүрэг болгосугай.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

ТӨСӨЛ
Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оныдугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДЭВ

№	Аудитын сэдэв	Хамрах хүрээ	Аудит хийх хугацаа	Аудитын тайлан дүгнэлтийг хүргүүлэх
Нэг. Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх аудитын сэдэв				
1	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Сангийн яам	2022.05.10-06.10	Улсын Их хурал
2	Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	Сангийн яам	2022.05.10-06.10	Улсын Их хурал
3	Сангийн Яамны 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх	Сангийн яам	2022.04.15-05.05	Сангийн сайд
4	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	Төсвийн ерөнхийлөн захирагчид	2022.03.26-04.25	Төсвийн ерөнхийлөн захирагч
5	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	Төсвийн төвлөрүүлэн захирагчид	2022.02.26-03.25	Төсвийн төвлөрүүлэн захирагч
6	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	Засгийн газрын тусгай сангууд	2022.01.05-02.25	Төсвийн ерөнхийлөн захирагч
7	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	Холбогдох аж ахуйн нэгжүүд	2022.02.15-03.15	Төсвийн ерөнхийлөн захирагч
8	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	Төсөл, хөтөлбөрүүд	2022.01.05-02.25	Төсвийн ерөнхийлөн захирагч
9	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	Төсвийн шууд захирагчид	2022.01.05-02.25	Төсвийн шууд захирагч

10	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	Холбогдох гэрээлэгч компаниуд	2022.08.05-12.15	Эдийн засгийн байнгын хороо
11	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020-2021 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	"Доншен газрын тос (Монгол)" ХХК	2022.08.05-12.15	Эдийн засгийн байнгын хороо
12	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020-2021 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан "Петроочайна дачин тамсаг Монгол" ХХК-ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	"Петроочайна дачин тамсаг Монгол" ХХК	2022.08.05-12.15	Эдийн засгийн байнгын хороо
13	Дипломат төлөөлөгчийн газрын 2019, 2020, 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх	Дипломат төлөөлөгчийн газрууд	2022.07.15-11.10	Төсвийн ерөнхийлөн захирагч
14	Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	Сангийн яам	2022.09.05-10.15	Төсвийн байнгын хороо
15	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалт	Холбогдох газрууд	2022.02.05-07.01	Тусгай хяналтын дэд хороо
16	Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	Бүх шатны төсвийн захирагч	2022.01.04-06.10	Төсвийн байнгын хороо
17	Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн	Засгийн газар, Сангийн яам	2022.01.25-06.10	Төсвийн байнгын хороо

Хоёр. Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв

18	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүн	Засгийн газар, холбогдох бусад байгууллагууд	2022.02.01-06.15	Төсвийн байнгын хороо
19	Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн	Засгийн газар, АМГТГ, холбогдох байгууллагууд	2022.01.05-04.10	Эдийн засгийн байнгын хороо
20	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн	Засгийн газар, холбогдох бусад байгууллагууд	2022.06.05-10.10	Нийгмийн бодлогын байнгын хороо
21	Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн	БСШУЯ, их дээд сургуулиуд	2022.06.05-10.15	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын байнгын хороо
22	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр ашиг	Засгийн газар, ТБОНӨААН	2022.05.02-12.01	Төсвийн байнгын хороо

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг боловсруулан Төсвийн байнгын хорооны хуралдаанаар шийдвэрлүүлэхээр Та бүхэнд танилцуулж байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд болон бодлогоор гүйцэтгэх аудитын нийт 22 сэдвийг төлөвлөснөөс хууль тогтоомжийн дагуу 17, бодлогоор гүйцэтгэх 5 аудит байна.

Аудитын сэдвийг хуульд заасны дагуу хийх болон бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвээр ангилан төлөвлөлтийн өмнөх үеийн судалгаа, эрсдэлийн үнэлгээ, тооцоолол төрийн аудитын байгууллагын батлагдсан төсөв, хүний нөөцийн ажлын ачаалал зэргийг харгалзсан болно.

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаа буюу 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 6 дугаар сарын 15-ны хооронд улс, орон нутгийн төсөвт байгууллага, сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлнэ.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийх аудитыг 2019-2021 оныг хамруулан аудитыг гүйцэтгэнэ.

Мөн Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, Өрийн удирдлагын тухай хуулийн хүрээнд “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн” зэрэг сэдвээр улс, орон нутгийн төвшинд аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэхээр боловсрууллаа.

Бодлогоор дараах 5 сэдвээр аудитыг гүйцэтгэхээр төлөвлөсөн болно. Үүнд:

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүн
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн
- Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн
- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр ашиг

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН
САНАЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

АУДИТЫН СЭДЭВ	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас 2020-2021 урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, зарцуулсан хөрөнгийн үр дүн
Хамрах хүрээ:	Монгол Улсын Ерөнхий Сайд, Сангийн сайд, Шадар сайд, ЭМЯ холбогдох бусад байгууллага
Аудит хийх үндэслэл, шаардлага:	2020 оны 01 дүгээр сараас эхлэн Монгол Улс хилээ хааж, 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталсан байна.
Товч танилцуулга /судалгаа/:	Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, вакцинжуулах, эмчлэх, иргэд, аж ахуй нэгжийг дэмжих, гадаадын улс орнуудтай хамтран ажиллах, харилцан туслалцах зэрэг бусад олон ажлыг хийж хэрэгжүүлээд байна.
Шалгагдагч этгээдийн аудитад хамрах хүрээний асуудлын төсөв хөрөнгө, хууль дүрэм, журам:	Монгол Улс КОВИД-19 цар тахалтай тэмцэхэд 2020 онд 2.4 их наяд төгрөг, 2021 онд 1.7 тэрбум төгрөг тус тус зарцуулаад байна.
Яагаад энэ асуудалд аудит хийх шаардлагатай гэж үзсэн талаарх мэдээлэл:	Ковид-19 цар тахлын эсрэг зарцуулсан хөрөнгийн үр дүнд аудит хийж олон нийтийн хүлээлттэй байгаа асуултад хариулт өгөх, холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэх цаг үеийн зайлшгүй шаардлага бий болсон.
Судалж шалгах гол асуудлыг тодорхойлох:	
Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулсан хөрөнгийн үр дүнд аудит хийснээр Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцоолох, эргэн харж дүгнэлт хийх, ирээдүйн дүр зураглалыг гаргах, үр өгөөжийг тодорхойлох, холбогдох албан тушаалтанд дүгнэлт зөвлөмжийг хүргүүлнэ.	
УИХ, олон нийтийн анхааралд байгаа эсэх:	Тийм.
Санал болгох аудитын арга зүй:	Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 100, 3000-3100), Аудит хийх журам, арга зүйг ашиглан аудитад хамрагдаж буй байгууллагуудаас гаргуулсан авсан баримт материалыг судлах, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, холбогдох мэдээ тайлан, баримт материалд тулгуурлан аудитын горим арга зүйг хэрэгжүүлнэ.
Шаардагдах хүн өдөр:	275 хүн өдөр

Уг аудитыг хийснээр гарах боломжтой санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөж:	Холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлэх, олон нийтийн хүлээлттэй байгаа асуудалд тодорхой хариулт өгөх, Ковид-19 цар тахлын эсрэг зарцуулсан хөрөнгийн санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөж нэмэгдэж тооцогдох боломжтой болно.
--------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

----oO----

**2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН
САНАЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

АУДИТЫН СЭДЭВ	Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн
Хамрах хүрээ:	Холбогдох яам, төрийн байгууллага
Аудит хийх үндэслэл, шаардлага:	<p>Монгол Улсад газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг онцгой болон албан татваргүйгээр импортолж байна. Олон улсад газрын тос, нефтийн засварын нэмэлт бүтээгдэхүүнд онцгой албан татварыг бусад төрлийн татвараас өндөр тогтоодог ба манай улсын импортоор оруулж ирж байгаа газрын тос, нефтийн засварын нэмэлт бүтээгдэхүүний төрлийн хэрэглээг хязгаарласан байдаг.</p> <p>Монгол хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж, агаар, орчны бохирдлыг үүсгэж байгаа гол эх үүсвэрт газрын тос, нефтийн засварын нэмэлт бүтээгдэхүүн, хуурамч шатахууны хэрэглээ ихэссэн асуудал орж байна. Агаарын бохирдол үүсэх үндсэн шалтгааны нэг болж хүний эрүүл, мэнд, амьдрах орчинд сөргөөр нөлөөлж автомашины эдэлгээг богиносгох, хөдөлгүүрийн чанарыг бууруулах, хэрэглэгчдийн эрх ашгийг ноцтой зөрчсөн үндэсний аюулгүй байдалд аюул учруулах муу үр дагавартай байна.</p>
Товч танилцуулга /судалгаа/:	<p>2017 оны 12 дугаар сард УУХҮЯ-аас завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг онцгой албан татвартай болгох хуулийн төслийг Сангийн Яаманд хүргүүлсэн байна. Гэвч өнөөдрийг хүртэл энэхүү асуудалд бодлогын болон хариуцлага, хяналтын ямар нэг тогтолцоо, хөшүүрэг, алхамыг хийгээгүй хуурамч шатахууны бизнес цэцэглэж иргэд олон нийт, бидний хүрээлэн буй орчин, автомашин, тоног төхөөрөмжийн ашиглалт, эвдрэлд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах үндсэн хуулийн заалт хэрэгжих боломжгүй үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх түвшинд байна.</p> <p>Сүүлийн 2018-2020 он хүртэлх газрын тос нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний татварын үзүүлэлтэд судалгаа, шинжилгээ хийж тооцоход ойролцоогоор 181.7 тэрбум төгрөгийн онцгой болон албан татварыг Улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.</p>
Яагаад энэ асуудалд аудит хийх шаардлагатай гэж үзсэн талаарх мэдээлэл:	Агаар орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр төрийн бодлогыг хэрэгжүүлэх, экологийн өндөр ангилал бүхий чанар, стандартын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг татварын бодлогоор дэмжих, байгаль орчинд ээлгүй, экологийн бага ангилал бүхий шатахууны хэрэглээг хязгаарлах хууль, эрх зүйн бодлогын орчинг бүрдүүлэх, чанарын хяналтын цогц тогтолцоог бий болгох шаардлагатай тул энэхүү аудитыг зайлшгүй хийх ёстой гэж үзэж байна.

Судалж шалгах гол асуудлыг тодорхойлох:	
Газрын тос, нефтийн завсрын бүтээгдэхүүнд хэрэв холбогдох татварыг ногдуулж Улсын төсөвт төвлөрүүлэх байсан алдагдсан боломжийг нарийвчлан тооцож аудитлахаар бол ААНБ-ын тухайн бараа бүтээгдэхүүнийг ямар зориулалтаар ашигласан, үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэлээр баталгаажуулж бусад хамаарах асуудлыг харгалзан авч үзэх ёстой болно.	
УИХ, олон нийтийн анхааралд байгаа эсэх:	Хэвлэл мэдээллийн байгууллага, иргэд олон нийт, Улсын Их Хурал, гишүүдийн анхаарал татсан эрсдэл ихтэй аудитын сэдэв болно.
Санал болгох аудитын арга зүй:	Гүйцэтгэл, нийцлийн аудитын арга зүйг ашиглана.

-----oOo-----

**2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН
САНАЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

АУДИТЫН СЭДЭВ:	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн
Хамрах хүрээ:	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
Аудит хийх үндэслэл, шаардлага:	Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал, Ковид-19 гарсантай холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийн тоо буурч иргэдийн амьдралд бодит хохирол үүсэж байна.
Товч танилцуулга /судалгаа/:	<p>Дэлхий нийтэд Хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр 2030 он гэхэд 600 саяас дээш ажлын байрыг шинээр бий болгох хэрэгцээ гарч байна. Энэ нь жил бүр 40 сая ажлын байр шаардагдана гэсэн судалгаа байна. Үүний нэгэн адилаар манай орны хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж байгаагаас хөдөлмөр эрхлэлтийн тоо буурч ард иргэдийн амьдралд ядуурал нэмэгдэж байна.</p> <p>2020 оны IV улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын 1216.6 мянга (56.9 хувь) нь ажиллах хүч, 918.1 мянга (42.1 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Мөн нийт ажиллах хүчний 1 124.6 мянга (92.4 хувь) нь ажиллагчид, 92.1 мянга (7.6 хувь) нь ажилгүйчүүд байна. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 77.0 мянга буюу 6.0 хувиар буурсан байна. Ажиллах хүч буурсан нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гэж таамаглаж болохоор байна. Тухайлбал ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 13.0 мянга буюу 13.4 хувиар буурч, боломжит ажиллах хүч 8.1 мянга буюу 13.9 хувиар өссөн байна. Тоон мэдээллээс үзэхэд Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы нөлөөгөөр ажилгүй хүмүүсийн ажил хайх болон ажил хийх оролдлого нь хязгаарлагдсан нь харагдаж байна.</p> <p>Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хүн ам 2020 оны IV улирлын байдлаар улсын хэмжээнд 166.4 мянга болж, 2019 оны IV улирлаас 7.9 мянга буюу 4.5 хувиар буурсан байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 92.6 мянга (55.4 хувь) нь ажилгүй хүн, 8.2 мянга (4.9 хувь) нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, 66.1 мянга (39.7 хувь) нь боломжит ажиллах хүч байна.</p>
Шалгагдагч этгээдийн аудитад хамрах хүрээний асуудлын төсөв хөрөнгө, хууль дүрэм, журам:	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам", Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, туунд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам", Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоол

<p>Яагаад энэ асуудалд аудит хийх шаардлагатай гэж үзсэн талаарх мэдээлэл:</p>	<p>Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2014-2025, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021-2022 онуудад хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг баталсан. Хөтөлбөрийн хугацаа: 2021/04/01-2021/07/01</p> <p>Хөтөлбөрүүд нь цар тахлын үед ажлын байрыг хадгалах, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх, зорилтот бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн шинэлэг арга хэмжээг тусгах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх замаар “Халамжаас хөдөлмөрт шилжих” зорилт руу чиглэсэн байна. Үүнд дараах хөтөлбөрүүд багтсан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр 2. Цар тахал үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр 3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
<p>Судалж шалгах гол асуудлыг тодорхойлох:</p>	
<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажиллах хүчний хэрэгцээг хангах, амьдралын түвшнийг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, түүний өсөлтийг урамшуулах зорилгоор үр ашигтай, бүрэн, чөлөөт хөдөлмөр эрхлэлтийн сонголтод дэмжлэг үзүүлэхэд бодлогыг хэрэгжүүлснээр төсвөөс гарах халамжийн зарлага буурч татварын орлого нэмэгдэж иргэдийн амьдрал сайжирна.</p>	
<p>УИХ, олон нийтийн анхааралд байгаа эсэх:</p>	<p>Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2015-2025 /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ Ажилгүйдлийн тоо нэмэгдэж байгаа нь олон нийтийн анхааралд байнга байдаг төдийгүй байсаарч байх асуудал юм.</p>
<p>Санал болгох аудитын арга зүй:</p>	<p>Гүйцэтгэлийн аудит</p>
<p>Шаардагдах хүн өдөр:</p>	<p>540 хүн өдөр</p>
<p>Уг аудитыг хийснээр гарах боломжтой санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөж:</p>	<p>Хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдсэнээр төсөв төлөх татварын орлого нэмэгдэн. Иргэдийн амьдралын түвшин нэмэгдэнэ. Зохистой хөдөлмөр эрхэлснээр хүмүүс, гэр бүлүүд мөнгөтэй болж, худалдан авалт хийх замаар орон нутгийнхаа эдийн засагт хувь нэмэр оруулна. Мөн хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдэнэ гэдэг нь эдийн засаг илүү хурдацтай, хүртээмжтэй өснө гэсэн үг. Өсөлт ийнхүү сайжирснаар зохистой ажлын байр бий болгоход зарцуулагдах нөөц нэмэгдэнэ</p>

**2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН
САНАЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

АУДИТЫН СЭДЭВ	Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн
Хамрах хүрээ:	Боловсрол, шинжлэх ухааны яам, Улсын болон хувийн хэвшлийн их дээд сургуулиуд
Аудит хийх үндэслэл, шаардлага:	<p>ҮАГ-аас боловсролын салбарт дараах гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн өмчийн их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүн"-д 2015 онд гүйцэтгэлийн аудит", • "Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн" – 2019 он • "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн" – 2020 он
Товч танилцуулга /судалгаа/:	<p>2019-2020 оны хичээлийн жилд дээд боловсролын байгууллагад нийт 148,446 оюутан суралцаж байгаагаас 17,566 нь шинээр элсэн орж 23,038 оюутан төгссөн байна. 2019-2020 оны хичээлийн жилд Монгол улсад нийт 95 их дээд сургууль үйл ажиллагаа явуулж буй бөгөөд үүнээс 36.8 хувь нь их сургууль, 52.6 хувь нь дээд сургууль, 7.4 хувь нь коллежийн ангилалд багтаж, 3.2 хувь нь гадаадын салбар сургууль байна. Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 119.3 мянга (80.4 %) нь бакалавр, 25.8 мянга (17.3 %) нь магистр, 3.4 мянга (2.3 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна.</p>
Шалгагдагч этгээдийн аудитад хамрах хүрээний асуудлын төсөв хөрөнгө, хууль дүрэм, журам:	<p>Монгол Улсын нэгдсэн төсвөөс боловсролын салбарт 2019 онд 1.7 их наяд, 2020 онд 1.6 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь 2019 онд 15.3 хувь байсан бол 2020 онд 11.8 хувь болж 3.5 пунктээр буурсан байна. Улсын хэмжээнд нэг хүнд ногдох боловсролын зардал 2019 онд 547.3 мянган төгрөг байсан бол 2020 онд 510.1 мянган төгрөг болж буурсан байна. Төсвөөс олгосон санхүүжилтийг нарийвчлан авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй дотоодын оюутнуудад 99.9 тэрбум төгрөгийг, Монголд суралцаж буй гадаад оюутнуудад 0.9 тэрбум төгрөгийг, харин гадаадад суралцаж буй Монгол оюутнуудад зориулан 25.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль.</p>
Яагаад энэ асуудалд аудит хийх шаардлагатай гэж үзсэн талаарх мэдээлэл:	<p>2019-2020 онд сургуулийн өмнөх, бүх нийтийн ерөнхий боловсролыг аудитад хамруулж үзсэн бөгөөд их дээд боловсролыг өнөөгийн байдлыг судалснаар Монголын боловсролын тогтолцоо, өнөөгийн байдал, үр дүнг цогцоор нь үзэх боломжтой.</p>
Судалж шалгах гол асуудлыг тодорхойлох:	

УИХ, олон нийтийн анхааралд байгаа эсэх:	Тийм.
Санал болгох аудитын арга зүй:	Уулзалт ярилцлага хийх, нотлох баримт цуглуулах, дээд боловсролын байгууллагуудын чанарын судалгаа шинжилгээний ажлуудтай танилцах
Шаардагдах хүн өдөр:	170 хүн/өдөр
Уг аудитыг хийснээр гарах боломжтой санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөж:	Бодлогын хэрэгжилтийн чанар, үр нөлөөг сайжруулах

---o0o---

**2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН
САНАЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

АУДИТЫН СЭДЭВ:	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр ашиг
Хамрах хүрээ:	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, 439 Төрийн болон орон нутгийн өмчит ААН, ОНӨААН
Аудит хийх үндэслэл, шаардлага:	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ" гэж заасны дагуу 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг боловсруулсан. УИХ-ын Төсвийн байнгын хорооноос аудитын сэдвийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг нэгдсэн удирдамжаар хэрэгжүүлэх санал ирүүлсэн.
Товч танилцуулга /судалгаа/:	ҮАГ-ын мэдээллийн санд төрийн өмчит 146, орон нутгийн өмчит 421, нийт 567 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байна. 2020 оны эхээр төрийн болон орон нутгийн өмчит компанийн нийт хөрөнгийн дүн 40 орчим их наяд төгрөгт хүрч, 1.5 их наяд төгрөгийн ашигтай ажилласан байдаг. Харин бусад компаниуд 387.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан буюу 70 орчим хувь нь байна. Төсөвт тодорхой үр ашиг өгч чаддаггүй төрийн өмчит компаниудад бүтцийн өөрчлөлт хийх замаар, өгөөжийг нь өсгөж, төсөвт оруулах орлогыг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гаргасан мэдээллээр, улсын хэмжээнд төрийн өмчит компаниудад 54 мянга орчим ажилтан ажиллаж байна.
Шалгагдагч этгээдийн аудитад хамрах хүрээний асуудлын төсөв хөрөнгө, хууль дүрэм, журам:	Шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж байна.
Яагаад энэ асуудалд аудит хийх шаардлагатай гэж үзсэн талаарх мэдээлэл:	Төрийн аудитын байгууллага төрийн өмчит 157 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан санхүүгийн тайлангийн аудитыг хэрэгжүүлж, зөрчилгүй 127, хязгаарлалттай 17, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Аудитаар нийт 1,063.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 856.8 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 1.6 тэрбум төгрөгийн зөрчилд 53 акт тогтоож, 145.3 тэрбум төгрөгийн зөрчилд 237 албан шаардлага, 60.0 тэрбум төгрөгийн зөрчилд 448 зөвлөмж өгчээ.
Судалж шалгах гол асуудлыг тодорхойлох:	
<ol style="list-style-type: none"> 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүртгэл, дотоод хяналт хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй эсэх асуудал 2. Хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй засаглалын хариуцлагатай, ил тод тогтолцоо хэрэгжсэн эсэх асуудал 3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн боломжит нөөцөөс үр ашиг хүртэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн эсэх асуудал 4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, нэгдсэн санг бий болгох асуудал 	

<p>5. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөрийг барагдуулах, алдагдлыг бууруулах зэрэг үйл ажиллагааны үр дүнг удирдлагын ажлын гүйцэтгэлтэй уялдуулан дүгнэх, үр нөлөөг тодорхойлох асуудал</p> <p>6. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага, өглөг, өр төлбөр алдагдал их хэмжээгээр өсч буй нөхцөл шалтгааныг тодорхойлох, шийдвэрлэх үйл ажиллагааг сайжруулах асуудал</p>	
<p>УИХ, олон нийтийн анхааралд байгаа эсэх:</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчит компаниуд жил бүр 200-300 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байна. Олон жил ашиггүй байсан, үр дүнгүй, алдагдалтай, зардал ихтэй, хөрөнгийн удирдлагын менежмент сул төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд бүтцийн өөрчлөлт хийхээр удаа дараа асуудлыг УИХ-ын төвшинд хэлэлцэгдэж байна. Тиймээс эдгээр компаниудад үнэлгээ хийж, тодорхой чиглэлээр бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай байгаа асуудал УИХ, Засгийн газрын анхааралд байна.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх компанийн худалдан авалт, хөрөнгө оруулалтыг худалдан авах ажиллагааны хуулиар зохицуулах, шилэн дансны хэрэгжилтийг 100 хувь хэрэгжүүлэх асуудал олон нийтийн анхааралд байна.</p>
<p>Санал болгох аудитын арга зүй:</p>	<p>Гүйцэтгэл, нийцлийн аудитын стандарт, арга зүй, аргачлалын хүрээнд шууд тайлагнаж хэрэгжүүлнэ. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах хүрээнд гүйцэтгэлийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан нэгдмэл байдлаар хэрэгжүүлнэ.</p>
<p>Шаардагдах хүн өдөр:</p>	<p>Аудитыг ҮАГ-аас 28, АНТАГ-аас 96, гэрээт 10 аудитор гүйцэтгэж нийт 13700 хүн өдөр зарцуулахаар төлөвлөвөө.</p>